



БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ТАЗРЫН
ДАРГА

С.ЭНХБАЯР

2023 оны 12 дугаар сарын 27 өдөр

**ЗХЗ САГСАН БӨМБӨГИЙН ТАЛБАЙ БАЙГУУЛАХ АЖИЛ (15, 20, 24 ДҮГЭЭР ХОРОО)-ЫН
ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	- Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний 26 дугаар тогтоол.
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Төв цэнгэлдэхийн баруун урд - Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо, Цагаан орд хотхон - Хан-Уул дүүрэг, 24 дүгээр хороо, Богд вилла хотхон
3	Зориулалт хүчин чадал	- Сагсан бөмбөгийн 3x3 талбай шинээр байгуулах ажил
4	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
5	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
6	Төсөл гүйцэтгэх байгууллага	- Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан гадна, дотор засал чимэглэл, орчны тохижилтын зураг төсөв боловсруулах болон ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж оролцох боломжтой.
7	Ажил гүйцэтгэх үе шат	- Талбайн судалгаа, хэмжилт хийх. (Ажлын тоо хэмжээг захиалагч байгууллагатай зөвшилцөн батлуулах) - Инженер геологийн судалгаа, дүгнэлт гаргуулах. - Захиалагч болон мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх. - Загвар зураг болон ажлын зураг төсөв боловсруулж батлуулах. - Төсөвт өртөг (магадлал хийгдсэн байх). - Батлагдсан зураг төсвийн дагуу ажил гүйцэтгэх.
8	Орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	Архитектур орон зай төлөвлөлтийг тус байршлын онцлог, шаардлага, орц гарц, орчны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж тохижилтын шийдэл гаргаж төлөвлөх. Сагсан бөмбөгийн талбай: - Тус ажилд ашиглах материал сонгохдоо орчин үеийн дэвшилтэд технологи нэвтрүүлсэн. Монгол улсын стандартад нийцсэн материал байх - Сагсан бөмбөгийн хашааг стандартын дагуу чанартай засварлаж хийж гүйцэтгэх. /Шон, босоо, хөндлөвч, тор зэргийг бат бөх байхаар тооцож чанартай материалаар сонгон хийж гүйцэтгэнэ.

		<ul style="list-style-type: none"> - Сагсан бөмбөгийн талбайн шалыг зориулалтын угсардаг 1.8 см-ээс багагүй зузаантай, резин байхаар төлөвлөх <p><u>Явган зам, талбай:</u></p> <ul style="list-style-type: none"> - Зорчигчдын амрах талбай болон хүний хөдөлгөөнийг салгаж зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулах орц гарцыг нэмэгдүүлж төлөвлөх. - Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009 стандарт. <p><u>Бусад</u></p> <ul style="list-style-type: none"> - Гэрэлтүүлгийг орчин үеийн загвартай эрчим хүчинд хэмнэлттэй гэрэлтүүлэг шинээр төлөвлөх. Одоо ашиглагдаж байгаа нийтийн эзэмшлийн гудамж зам гэрэлтүүлгээс тэжээл авах.
9	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Монгол Улсын хуулиуд</u></p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль - Барилгын тухай хууль - Бусад холбогдох хууль <p><u>Төсөл хөтөлбөрүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05 - Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь, норм, түүний хавсралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм БНБД 981-10-02 - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД30-01-04/. - Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/. - Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм. - Бусад холбогдох норм, дүрэм. <p><u>Стандартууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага" MNS 4990:2000 - Хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ UCS0001-02:2019 - Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөмжид тавигдах шаардлага UCS1901B:2020 - Ажлын байрны бичил цаг уурын эрүүл ахуйн хэмжээ MNS 12.013-91 - Бусад холбогдох стандартууд.
10	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.
11	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Ажил эхлэх үед холбогдох хүмүүст мэдэгдэж хийгдэх ажлын дараалал, хугацааг тодорхой болгож мэдээллэнэ. - Архитектур төлөвлөлтийн даалгаврыг холбогдох байгууллагаас авах - Төсвийг зохиохдоо заавал ажлын талбарт очиж, хэмжилт хийн фото зургаар баталгаажуулах

		<ul style="list-style-type: none">- Тохижилтын стандарт мөрдөн төлөвлөх.- Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичгийг мөрдөн төлөвлөх.
--	--	---

- Зураг төсвийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, зориулалтыг өөрчлөхгүйгээр төсөвт өртөгт багтаах. Төсөвт өртөг хэтэрсэн тохиолдолд ажлын зураг батлагдахгүй болно.
- Зураг төсвийн болон ажил гүйцэтгэх явцад хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг хатуу мөрдөж ажиллах.
- Эрүүл аюулгүй, чанарын шаардлага хангасан материал сонгох /БНБД-д заасан/. Зөвшөөрөгдсөн лаборатори, гарал үүслийн, сертификаттай баталгаат материалыг ашиглах.

ХЯНАСАН:

**ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА**


Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

**ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН**

Г.ЛУВСАНЖАМЪЯН

15 ДУГААР ХОРОО, ТӨВ ЦЭНГЭЛДЭХИЙН УРД



20 ДУГААР ХОРОО, ЦАГААН ОРД ХОТХОН



24 ДҮГЭЭР ХОРОО, БОГД ВИЛЛА ХОТХОН

